

Аман болон бичгийн орчуулга хосолсон сургалтын загварт хийсэн судалгаа

Zhang Wei 1 Wang Ke fei 2

- (1. Бээжин Гадаад хэлний их сургууль Англи хэлний сургууль 100089;
2. Бээжин Гадаад хэлний их сургууль Гадаад хэлний боловсрол, судалгааны төв 100089)

Товч агуулга: Энэхүү өгүүлэлдээ бичгийн орчуулгын сургалт нь аман орчуулга хийхэд чухам ямар үүрэг нөлөөтэй болохыг судлахыг зорилоо. Өөр өөр орчуулагчдын хөрвүүлсэн бичгийн орчуулгын материалаас үзэхэд: 1.Бичгийн орчуулгад дадлагажуулах нь аман орчуулгад суралцах үр дүнд маш чухал үүрэгтэй байна. 2. Бүхэлд нь авч үзвэл, бичгийн орчуулгын дадлага аман орчуулга хийх онцлогт нийцэхийн хэрээр аман орчуулгын сургалтад нөлөөлөх нөлөө тэр хэмжээгээр нэмэгддэг. 3.Бичгийн орчуулгад суралцах нь аман орчуулга хийх туршлага хуримтлуулах, ур чадвараа дээшлүүлэхэд нь нөлөөлдөг. Энэ туршилтын үр дүнд ам, бичгийн орчуулгыг хамтатгасан сургалтын загварт дүн шинжилгээ хийж цаашид түүнийг хэрхэн сайжруулах, аман орчуулга заах арга болон сурах бичгийн чанарыг сайжруулахад тус дөхөм болох юм.

Түлхүүр үг: бичгийн орчуулгын дадлага, аман орчуулгад суралцахуй, нэгдмэл загвар

1. Удиртгал

Орчуулгыг практикт аман болон бичгийн орчуулга гэж ангилдаг бөгөөд аман орчуулга /хэлмэрчлэхүй/ нь орчуулагчийн тусламжтайгаар нэг хэлнээс нөгөө хэл рүү буулган хөрвүүлэх, мэдээллийг дамжуулахыг чухалчилдаг бол бичгийн орчуулга нь гол нь орчуулагч хүн бичгийн хэлээр уг эхийн хэлний онцлог, цаад утга санаа, агуулгыг алдагдуулалгүй, бүрэн төгс буулган орчуулах явдал юм. Үүний зэрэгцээ аман болон бичгийн орчуулга хийхэд орчуулгын хэм хэмжээ, арга барилын хувьд өөрийн онцлогтой байдаг. Иймээс орчуулгын сургалтын практик явцад, аман, бичгийн орчуулга хийх стандарт, танин мэдэхүйн тогтолцоо, чанарын үнэлгээний талаарх ялгааг тодорхойлох, аман, бичгийн орчуулгын бие даасан сургалт явуулахын чухлыг бататгах, нөгөө талаар орчуулгын түгээмэл шинжийг хүлээн зөвшөөрч, аман болон бичгийн орчуулгын сургалтын харилцан нөлөөллийг бодитой үнэлэх, бүх түвшний, олон хэв шинж бүхий ам бичгийн орчуулга хосолсон сургалтын загварыг бий болгохыг эрэлхийлэх, орчуулга заах аргын шинэчлэл, аман болон бичгийн орчуулгын ур чадварын харилцан нөлөөллийг үр дүнтэй нэвтрүүлж, орчуулга заах арга, дадлагын чанарыг сайжруулах явдал юм.

2. Судлагдсан байдал

2.1. Аман орчуулгын сургалтын өвөрмөц онцлог

Онолын судалгаанаас үзэхэд (Gile, 2009) орчуулах дэс дараалал,анхаарах зүйл, цаг хугацааны хувьд аман болон бичгийн орчуулга нь.... сургалтын зорилго, зохион байгуулах хэлбэр, материал хэрэглэгдхүүн, арга барил, үр дүнг үнэлэх зэрэг тал дээр хоорондоо ялгаа, зөрөөтэй байдаг учраас практик үе шатанд аман орчуулгын өвөрмөц онцлог илэрхий байдаг, ялангуяа аман орчуулгын арга техникт сургахыг онцгой анхаарах хэрэгтэйг судлаачид (仲伟合, 2007; 文军 刘威, 2007; 罗选民 等, 2008; 刘银燕 张珊珊, 2009) онцлон тэмдэглэсэн байна.

Сургалтын практик үе шатанд, бичгийн болон аман орчуулга нь тухайн хэлний үндсэн суурь мэдлэг,нэр томъёо, орчуулах дэс дараалалын хувьд ижил шинжтэй (刘宓庆, 2003) , бичгийн орчуулгын дадлага нь дотоод гадаадын их дээд сургуулиудын аман орчуулгын сургалтын тогтолцооны чухал бүрэлдхүүн хэсэг юм.

2.2. Аман орчуулгын сургалтанд бичгийн орчуулгын дадлага, туршлага түүний гүйцэтгэх үүрэг

Өнөөгийн байдлаар аман болон бичгийн орчуулгын сургалтын харилцан нөлөөллийг нарийвчлан судалсан тоо, баримт дутмаг байгаа учраас бид энэ талаар нэгэн судалгаа хийсэн бөгөөд судалгаанд маань 17-н их дээд сургуулийн аман орчуулга заадаг 46 –н багш хамрагдсан.

2.2.1. Бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад суралцахад нөлөөлөх нь

Тоо баримтаас үзэхэд, (зураг №1) судалгаанд оролцсон багш нарын дунд бичгийн орчуулгын дадлага нь аман орчуулгад суралцахад үр дүнтэйгээр нөлөөлдөг гэж үзэж байгаа харьцаа нь: (илт нөлөөлдөг, тодорхой нөлөөлдөг гэсэн үзүүлэлт нийлээд 26% -тай), үгүйсгэсэн үзүүлэлт нэлээд өндөр байгаа нь : илт нөлөөлдөггүй, тодорхой хэмжээгээр нөлөөлдөггүй гэж үзсэн нь нийт 32% -тай). Харин сайн мэдэхгүй гэсэн үзүүлэлт хамгийн өндөр 42-% тай байгаа нь ихэнх орчуулгын багш нар бичгийн орчуулгын дадлага, аман орчуулгын сургалтын харилцан нөлөөллийн талаар хараахан тодорхой ойлголтгүй, мөн олонх нь бичгийн орчуулгын дадлага нь аман орчуулгын сургалтанд ашиг тус багатай гэж үздэг, тэр ч байтугай орчуулах ур чадвар эзэмших үйл явцад саад учруулдаг гэж үздэгтэй холбоотой юм.

Зураг №1 Бичгийн орчуулга аман орчуулгад суралцахад нөлөөлөх нь

2.2.2. Аман болон бичгийн орчуулгын дадлагыг нэгтгэсэн загварчлал /Загварын үндсэн онол, баримтлал, зарчим/

Зураг №2 Судалгаанаас үзэхэд аман орчуулга заадаг багш нар ам, бичгийн орчуулгын хосолсон загварыг дэмжиж байгаа нь харьцангуй их (36%), эсрэг саналтай байгаа нь цөөн (27%) байна. Мөн нэлээд хувь (37%) нь энэ загварын талаар тодорхой саналгүй байна.

Дээрх тоо баримтаас үзэхэд, аман орчуулга заадаг багш нар, бичгийн орчуулга нь ярианы орчуулгад нөлөөлөх талаар нэлээд нухацтай хандаж байгаа ч ам, бичгийн орчуулга хосолсон сургалтын загварыг дэмжиж буй нь илт байна. Гэхдээ бодит туршилт судалгаа хийж, бодит тоо баримтад тулгуурлан улмаар заах аргын холбогдох судалгаа, шинжлэх ухааны эрэл хайгуулыг эхлүүлэх шаардлагатай байна.

Нөгөө талаар аман орчуулгын багш нар одоогийн энэ дагнасан аман болон бичгийн орчуулгын сургалтын тогтолцоо нь учир дутагдалтай, зохих өөрчлөлт хийж, аман орчуулгын сургалтын зохион байгуулалтыг боловсронгуй болгох нь сургалтын үр дүнг дээшлүүлнэ гэж үзэж байна.

Бичгийн орчуулга, аман орчуулгын сургалттай холбогдох тухайд багцалж үзвэл :

- 1) багш болон судлаачдын танин мэдэхүй туршлагатай холбоотой
- 2) бичгийн болон аман орчуулгын дадлагыг танхимын сургалтын үед хэрхэн уялдуулах, холбогдох агуулга, арга, материал хэрэглэгдхүүнийг яаж сонгох зэрэг нь хараахан нарийн судлагдаагүй
- 3) Сургалтын янз бүрийн үе шатанд бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад суралцахад хэрхэн нөлөөлдөг талаар хараахан нарийн тодорхой судалгаа аграагүй байна.

Эндээс үүдэн, бид бодит судалгаа хийж, сургалтын арга, сургалтын материалаа боловсронгуй болгосны үр дүнд аман орчуулгын танхимийн сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх шаардлага урган гарч байна.

3. Судалгааны арга

3.1 Судалгааны таамаглал

1) Бичгийн орчуулгын дадлага нь аман орчуулгын сургалтын үр дүнд дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлдөг.

2) Бичгийн орчуулгын хичээлийн агуулга нь аман орчуулгын хичээлийн агуулгатай нягт холбоотой байх тусам аман орчуулгын сургалтын үр өгөөжийг ахиулахад илт нөлөөлдөг.

3) Бичгийн орчуулгын хичээл аман орчуулгын сургалтын үр дүнд нөлөөлөх нь үечилсэн онцлогтой байдаг.

3.2 Судалгаанд оролцогч

Бээжингийн нэгэн томоохон их сургуулийн англи хэлний мэргэжлийн 3-р курсын 6-н ангиас 3-н ангийн аман орчуулгын анхан шатны түвшний суралцагч (долоо хоногт 2 цагаар судалдаг) нийт 73 –н суралцагч; тус сургуулийн аман орчуулгын чиглэлээр суралцдаг магистрын(MТI) 2-р ангийн 5 ангиас 3 ангийн 59 суралцагч, дээд шатны түвшний суралцагч (7 хоногт 4 цагийн мэргэжлийн хичээл ордог), мөн бусад төрлийн аман орчуулгын хичээл судалдаг суралцагчид хамрагдсан.

Хэлний ерөнхий чадварын тест /анхан шатны суралцагч ТЕМ 4, дээд түвшний суралцагч ТЕМ 8/, төрөл бүрийн сурлагаар сайнгүй хэсгийг хасаад, сүүлд 51 хүнийг сонгон авав /хүснэгт 1/.

3.3 Судалгааны төлөвлөгөө

Хүснэгт №1 Туршилтын төлөвлөгөө

Судлуулагч	Өөрчлөлт : Бичгийн орчуулгын дадал			Өөрчлөлтийн шалтгаан : Аман орчуулгын сургалтын үр дүн
	Бичгийн орчуулгагүй	Дан бичгийн орчуулга	Аман орчуулгын хэлбэр бүхий бичгийн орчуулга	
Аман орчуулгын анхан шатны түвшний суралцагч	17хүн	17хүн	17хүн	Хятад хэлнээс Англи хэлнээ орчуулах сорил
Аман орчуулгын дээд шатны түвшний суралцагч	17хүн	17хүн	17хүн	

3.4. Судалгааны хэрэглэгдэхүүн

1- рт, Бичгийн орчуулгын дадлагын материал. Аман орчуулгын дасгалын материал голлосон дасгал ажилуулах /3.5-ийг үз/.

2- рт, Аман орчуулгын сургалтын үр дүнг шалгах сорилын материал . Хятад хэлнээс Англи хэл рүү орчуулах CATI (China Accreditation Test of Translators and Interpreters) шалгалтын материалаас анхан шатны суралцагч 3-р түвшний, дээд шатны суралцагч 2-р түвшний материалыг хийж гүйцэтгэнэ.

3.5. Судалгааны дараалал

- 1- рт, Туршилт эхлэхийн өмнө аман орчуулгын эхний тестийг авч, суралцагчийн түвшинг шалгах ба аман орчуулгын 2 мэргэжлийн багшаар үнэлүүлнэ.
- 2- рт, Анхан болон дээд шатны хичээлийг дээрх 2 багшаар заалгаж, заасан анги бүрийг шалгана. Хугацаа 1 семестр, заах аргын явц, хэрэглэдэхүүн, сэдэв ижил байна.

4.Үр дүн

4.1. Ерөнхий үр дүн

Хүснэгт №2 Эхний болон сүүлийн сорилын харьцуулсан үзүүлэлт

Судлуулагч	Бичгийн орчуулгын дадлага	Эхний тест	Сүүлийн тест
аман орчуулга /анхан/	Бичгийн орчуулгагүй	83·0588/4·78893	83·6471/4·24177
аман орчуулга /дээд/	Бичгийн орчуулгагүй	85·1765/3·18660	85·6471/2·54807
аман орчуулгад суралцагч /анхан/	Дан бичгийн орчуулга	83·1765/4·31908	85·5294/3·04380
аман орчуулга /дээд/	Дан бичгийн орчуулга	86·1765/2·60373	88·8824/1·76360
аман орчуулга /анхан/	Аман орчуулгын шинж бүхий бичгийн орчуулга	84·3529/4·62252	87·8824/2·26060
аман орчуулга /дээд/	Аман орчуулгын шинж бүхий бичгийн орчуулга	85·7647/2·92680	86·8235/1·74052

4.2. Тодорхой үр дүн

4.2.1. Өөр өөр түвшний суралцагчдын зөрүүнд хийсэн дүн шинжилгээ

4.2.1.1. Эхний болон сүүлийн сорил шалгалт

Хүснэгт №3 Өөр өөр түвшний суралцагчийн тестийн үзүүлэлт

Судлуулагч	Эхний тест	Сүүлийн тест
Анхан шатны суралцагч	029/972	2272/114
Дээд шатны суралцагч	440/647	2371/104

5. Хэлэлцүүлэг

5.1. Бичгийн орчуулгын дадлага ба аман орчуулгын сургалтын үр дүнгийн харьцаа хамаарал

Нэгд, Баримт материалаас үзэхэд, бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад эерэг нөлөөлж байгаа нь тодорхой байна (анхан шатны сүүлийн сорилын зөрүү : $F(2, 48) = 7.095, < .05$; Дээд шатны сүүлийн сорилын зөрүү : $(2, 48) = 10.827, < .05$). Энэ нь бичгийн орчуулга нь аман орчуулгад дадлагажуулахад эерэгээр нөлөөлдөг гэдэг үзэл баримтлалын нэг чухал баримт болох ба багш аман орчуулгад сургах явцдаа бичгийн орчуулгын идэвхгүй байдлыг арилгахад тус дөхөм болно. /2.2.1-ийг үз/. Цаашид аман, бичгийн орчуулгыг хослуулах сургалтын шинэчлэлд зайлшгүй шаардлагатай үзэл баримтлал, онолын үндэс болох юм /5.4.2-ыг үз/.

Хоёрт, хэрвээ бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад эерэгээр нөлөөлж байгаа юм бол аман орчуулгад сургах нь бичгийн орчуулгын ур чадварт сайнаар нөлөөлж болох талаар мөн судлах хэрэгтэй. Ингэснээр орчуулгын хоёр хэлбэрийн хоорондын харилцааг танин мэдэж, орчуулгын сургалтад аман, бичгийн орчуулгыг зохистойгоор уялдуулахад чухал ач холбогдолтой болно. /5.4-ийг үз/.

Түүнээс гадна, гадаад хэлнээс эх хэлээрээ, эх хэлнээс гадаад хэлээр мэдээллийг хүлээн авах, илэрхийлэх, хөрвүүлэх загвар болон дараалал зэрэг тал дээр их зөрүүтэй байдаг(Miller & Kroll, 2002; Christoffels et al., 2006), бичгийн

орчуулгын аман орчуулгад нөлөөлөх нөлөө /хэр хэмжээ, үр дүн/ нь судалгааны шинэ сэдэв болох юм.

Тус судалгаа бүхэлдээ бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад нөлөөлөх үр дүнгийн харилцан нөлөөллийг тодруулахыг зорисон бөгөөд, хэдийгээр бичгийн орчуулгын дадлага аман орчуулгын чадварт үзүүлж буй нөлөө тодорхой байгаа ч дээрх хоёр орчуулгын үр дүн, учир шалтгааны харьцааг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөх хараахан боломжгүй, өөрөөр хэлбэл аман орчуулгын чадвар сайжирч байгаа нь хичээлээс гадуурх бусад хүчин зүйлээс болсон байх магадлалтай учир бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад нөлөөлөх явцыг бодитой магадлахын тулд илүү олон хүчин зүйлийг тооцоолж, бүрэн дүүрэн судалгаа явуулах шаардлагатай.

5.2. Бичгийн орчуулгын дадлагын арга барилын үүрэг, нөлөө

Бичгийн орчуулгын дадлагын агуулга болон аман орчуулгын үр дүн нь ижил харилцаатай байна /хүснэгт 5-ыг үз/. Бичгийн орчуулгын дадлагын агуулга, хэлбэр нь аман орчуулгын онцлогт нийцэх тусам аман орчуулгын үр дүнд нөлөөлөх эерэг нөлөө улам илүү болж байна.

Анхан шатны суралцагчдад бичгийн орчуулгын дадлагын арга барил аман орчуулгад их, бага хэмжээгээр үзүүлэх эерэг нөлөөллийн дэс дараалал нь: аман орчуулгын шинж бүхий бичгийн орчуулга, цэвэр бичгийн орчуулга, бичгийн орчуулгагүй, дээд шатны суралцагч: цэвэр бичгийн орчуулга, аман орчуулгын шинж бүхий бичгийн орчуулга, бичгийн орчуулгагүй /хүснэгт 5-ыг үз/ байна. Иймд “бичгийн орчуулгын дадлагын агуулга нь аман орчуулгын агуулгатай төстэй байх тусам аман орчуулгад үзүүлэх эерэг нөлөө улам нэмэгдэнэ ” гэсэн таамаглал /3.1-ийг үз/-ыг бүрэн батлаагүй, үүний шалтгаан нь 1) аман орчуулгын туршлага хуримтлагдахын хэрээр аман орчуулгын арга барил, эв дүй улам гүнзгийрч /үүнд нэр томъёоны зөв хэрэглээ, өгүүлбэрзүйн уян хатан хувиргал, цогцолборын холбоо/ (张维为, 2011; 杨承淑 邓敏君, 2011) бичгийн орчуулгын агуулга, хэр хэмжээ өсөх тусам аман орчуулгын практик дахь хэрэглээний нөлөө улам тодорхой болно.

2) үг хэлэх /илтгэл тавих, бичгийн илтгэл/ хэлмэрчлэх нь мэдээлэл дамжуулахад илтэд нөлөөлдөг(Pichhacker, 2004: 129 –130). Уг судалгаа аман орчуулгын сургалтын хэрэглэгдэхүүнийг нарийвчлан бүлэглэж ялгаагүй бөгөөд, зарим илтгэлийн шинжтэй материал нь анхан шатны суралцагчийн мэдээлэл хүлээн авах, бичвэрийг хөрвүүлэхэд үзүүлэх нөлөөг тодорхой болгох, бичгийн орчуулгын дадлагын хүндрэл, бэрхшээл нэмэгдэх нь анхан шатны суралцагчийн аман орчуулга хийхэд эерэгээр нөлөөлдөг эсэх нь тодорхойгүй байна.

Орчуулгын ур чадвар тодорхой хэмжээнд “түгээмэл шинж”-тэй /үгийн утгыг ялгах, өгүүлбэрзүйн тохиргоо/ байдаг ба аман болон бичгийн орчуулгын хэмээн нарийвчлан ялгахад төвөгтэй байдаг. Ихэнхдээ хэр хэмжээний хувьд ялгаатай байдаг болохоос шинж чанарын хувьд ялгаа байдаггүй. Иймээс, “цэвэр бичгийн орчуулга”, “цэвэр аман орчуулга”-ыг илүү нарийн, системтэй ангилж, дасгалын хүнд хөнгөн, аман орчуулгын зохицол холбоо, дэс дараалал гэх мэт хүчин зүйлийг харгалзан өөр өөр хэв шинжийн бичгийн болон аман орчуулгад сургах эерэг нөлөөллийн харилцааг улам илүү судлах хэрэгтэй.

5.3. Бичгийн орчуулгын дадлагын “Шугаман бус шинж”-ийн онцлог

Бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад эерэгээр нөлөөлөхөд аман орчуулгын туршлага чухал үүрэгтэй. Аман орчуулгад суралцах эхний үед төрөл бүрийн бичгийн орчуулгын дадлага эерэгээр нөлөөлж байгаа нь илүү их байна/хүснэгт 6/. Харин аман орчуулгын дадлага туршлага нэмэгдэхийн хэрээр цэвэр бичгийн орчуулгын туршлага нь аман орчуулгад аажмаар нөлөөлж, бичгийн хэлний болон аман ярианы орчуулах ур чадвар сайжирч байна ./5.2-ыг үз/. Бичгийн орчуулгын адил загвар нь аман орчуулгын туршлага харилцан адилгүй суралцагчдад өөр өөрөөр илэрч байна. Цэвэр бичгийн орчуулга аман орчуулгын харьцангуй арвин туршлагатай суралцагчдад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Харин аман орчуулгын шинж бүхий бичгийн орчуулга нь туршлага багатай суралцагчдад ярианы орчуулгын чадвараа дээшлүүлэхэд тустай байна. Энэ нь аман орчуулгад суралцах эхний үе шатанд суралцагчийн ярианы чадвар, ухамсарт хэрэглээ нь бүрэлдэх шатандаа байдаг ба бичгийн орчуулгын дадлага аман орчуулгад тавигдах шаардлагад нийцэх тусам аман орчуулгын чадварт

суралцах явц зөв хандлага руу чиглэх нь илүү тодорхой болж байгааг харуулж байна. Харин аман орчуулгын туршлага хуримтлагдаж нэмэгдэхэд ялангуяа аман орчуулгын дотоод чадавхи гүнзгийрэхийн хэрээр бичгийн орчуулгыг илүү амархан хүлээн авч, түүнийг хэлмэрчлэх чадвараа дээшлүүлэх арга барил болгож байна. Суралцагчийн практик-туршлага, ур чадварын дотоод танин мэдэхүй нь суралцагчийн шинэ мэдлэг хүлээн авахад сайнаар нөлөөлдөг байна. /艾森克 基恩, 2003/.

Энэ судалгаагаанаас үзэхэд цаашид аман орчуулгын туршлагын хүрээг төгөлдөржүүлэх шаардлагатай /3.2-ыг үз/, мөн судлуулагчдыг адил нөхцөлд байлгаж, жишиг тестийн түвшинг чангатгах, аман орчуулгын ур чадварын түвшинг тодорхойлохын зэрэгцээ судлуулагчдын хам цагийн орчуулгын баримтад тулгуурлан, бичгийн орчуулгын дадлага нь тэдний аман орчуулгын чадварын хөгжил, туршлага дадлагад нөлөөлөх эерэг нөлөөг илүү бодитой магадлан тогтоох шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

5.4. Ач холбогдол

5.4.1. Орчуулгын хувиргалын өвөрмөц ба нийтлэг шинжийн хувьд, бичгийн болон аман орчуулгыг боловсруулах явц, мэдээллийг дамжуулах загвар, чанарыг шалгах жишиг хэмжүүр зэрэг тал дээр тодорхой ялгаа байдаг(Gile, 2009). Орчуулгын хэлбэрийн өвөрмөц шинж нь онолын хувьд аман болон бичгийн орчуулга нь шинжлэх ухааны судалгааны систем дэх шинж, бүтэц, үүрэг болон харилцан уялдаа холбоотой салбарын харилцааг тодорхойлоход тустай болох төдийгүй заах аргын өвөрмөц ухагдахуун ойлголтыг бий болгож, заах аргын бие даасан тогтолцоо, загварыг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм (仲伟合 王斌华, 2010).

5.4.2. Аман орчуулгын сурах бичгийн загвар ба агуулга

Дээр дурьдсан аман орчуулгын танхимийн сургалтыг шинэчлэхтэй уялдан, аман орчуулгын сурах бичгийг зохиохдоо бичгийн орчуулгын материалыг аман орчуулгын материалтай уялдуулж хийх, гол зарчим, агуулгад зараах зүйлийг багтаан авч үзэх : 1. Нэгтгэсэн дасгал. Өөр өөр түвшнийг багтаасан нэг материал/үг зүй, өгүүлбэр зүй, эх/

2. Эх хэлнээс гадаад хэлрүү, гадаад хэлнээс эх хэлрүү хөрвүүлэх дасгал

Нэг ижил материал дээр ажиллаж хоёр хэлний ялгаатай талыг таньж мэдэх, түлхүүр үг хэллэг, гол өгүүлбэрийн загвар, эх цогцолборын холболт зэрэг аман орчуулгын зарчмыг ойлгож мэдэх

3.Материал нь цаг үеийн шинжтэй нийтлэг байх. Аман орчуулгын материал нь тухайн цаг үе, нийгмийн гол чухал халуун сэдвийг хөндсөн байх, гол холбогдох сэдвийн дагуух бичгийн орчуулгын материалд өгүүлбэр зүйн хувиргал, эхийн бүтэц талын нарийвчисан судалгааг хийнэ.

6. Дүгнэлт

Энэхүү туршилт судалгаагаар хийсэн эхний дүгнэлт бол:

1. Бичгийн орчуулгын дадлагын хичээл нь аман орчуулгын сургалттай маш их холбоотой, аман орчуулгын сургалтын үр дүнг ахиулахад илэрхий нөлөөлдөг.
2. Бичгийн орчуулгын дадлага хичээл нь аман орчуулгын сургалтын үйл ажиллагааны онцлогтой хэдий чинээ нийцэж байна аман орчуулгын сургалт төдий чинээ ахицтай байна.
3. Бичгийн орчуулгын дадлага аман орчуулгын сургалтын үр дүнд үе шаттайгаар нөлөөлдөг бөгөөд аман орчуулгад дадлагажих тусам бичгийн орчуулгын ур чадварт илт нөлөөлж аман орчуулгын сургалтын үр дүн төдий чинээ дээшилдэг байна.

Энэ удаагийн туршилтаар судалгаанд оролцогчид, бичгийн орчуулгын дадлагын шинж чанар болон агуулгад учир дутагдалтай зүйлс байсан бөгөөд цаашид оролцогчдыг тоог нэмэх, аман орчуулгын сорилын түвшинг чангатгах, аман болон бичгийн орчуулгын дасгалын агуулгыг илүү нарийвчлан сайжруулах, туршилтын тоо баримтын боловсруулалтыг сайжруулах, судалгаа, ажиглалтын аргыг ашиглах, тоо баримтын төрөл, хүрээ хэмжээг нэмэгдүүлэх, аман болон бичгийн

орчуулга хавсарсан сургалтын загварыг бий болгож боловсронгуй болгох шаардлагатай байна.